



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА Д.ДАМДИНДОРЖ ТАНАА

2024.08.02 № 02/687
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны эзлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (.Я. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 9. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



ГОСОНЦИНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



МОНГОЛ АРДЫН НАМ

ХӨВСГӨЛ АЙМАГ ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИТХ-ИЙН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АГУУЛГА

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 ЭРҮҮЛ МЭНД
- 1.2 БОЛОВСРОЛ
- 1.3 СОЁЛ СПОРТ
- 1.4 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ- ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.2 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.3 ТӨСӨВ САНХҮҮ- СТАТИСТИК

3. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1 ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
- 3.2 НОГООН СУМ ХӨТӨЛБӨР

4. ДЭД БҮТЭЦ СУМЫН ТОХЬЖИЛТЫН БОДЛОГО

- 4.1 ДЭД БҮТЭЦ
- 4.2 СУМЫН ТӨВИЙН ТОХЬЖИЛТ

5. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сумын МАН-ийн хорооны Тэргүүлэгчдүн

2024 оны ...р сарын ...өдрийн ... р тогтоолоор батлав.

Тосонцэнгэл сумын ИТХ-ийн 2024 оны сонгуульд МАН-аас дэвшүүлж буй

мөрийн хөтөлбөр

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
 - ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
 - ✓ МҮ-ын алсын хараа – 2050 хөгжлийн хөтөлбөр
 - ✓ Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр
 - ✓ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
 - ✓ 2024 оны УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр.
 - ✓ Тосонцэнгэл сумын ард иргэдийн санал.

УРИА: “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА”

ЗОРИЛГО: Иргэнд ээлтэй, амьдрах таатай орчинг бүрдүүлэн орон нутгийнхаа хөгжлийг хурдасгаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл мэндийн бодлого

- 1.1.1 Эмч сувилагч мэргэжлээр суралцаж буй оюутан залуусыг бодолгоор дэмжиж сумандаа ажиллах боломжийг бүрдүүлнэ.
 - 1.1.2 Одоо ажиллаж буй эмч сувилагчдаа мэргэжил дээшлүүлэн сургаж тоног төхөөрөмжтэй ажлуулж нарийн үзлэг оношлогоо хийдэг болгоно.
 - 1.1.3 Шүдний тоног төхөөрөмж, Эхо үзлэг, лабораторын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж илүү олон үзлэг шинжилгээг хийдэг болгоно.
 - 1.1.4 Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хүрээнд шүдний өвчлөлгүй хүүхэд аян Ургэлжлүүлэн, эх хүүхдэд зэлтэй сүм болгох зорилтыг хэрэгжүүлнэ.
 - 1.1.5 Сумын ЭМТ-д шүдний эмчийн цалинг төсөвт суулгаж, эмчийн орон тоог бий болгох талаар дээд шатны байгууллагад санал хүргүүлэн хэрэгжүүлнэ.
 - 1.1.6 Эрүүл чийрэг эр хүн үндэсний хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

3

A rectangular red ink stamp with a decorative border. Inside, there is a stylized signature in black ink. To the right of the signature, the word "RECEIVED" is printed vertically. Below "RECEIVED" is a large, bold number "3". At the bottom of the stamp, the file number "0000000003" is printed in blue ink. The entire stamp is set against a white background.

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 1.1.7 Элэг бүтэн Монгол, эрүүл шүд, умайн хүзүүний үзлэг оношлогоо, эрт илрүүлэг хөтөлбөрүүдэд иргэдийг идэвхтэй хамруулна.
- 1.1.8 Бүх төрлийн хавдрын эхлэл болсон хуванцар савыг хэрэглээнээс халж хуванцар савгүй сум болно.
- 1.1.9 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлж сэтгэл зүйн зөвөлгөөг мэргэжлийн сэтгэл зүйчээр өгүүлж ажил мэргэжилд зуучлах сургалт үйлчилгээнд хамруулна.
- 1.1.10 Яаралтай тусlamжийн сүлжээний чадавхыг дээшлүүлж сумын ЭМТ багийн эмчийн эрүүл мэнд, эмийн хангамжийг сайжруулж, түргэн тусlamжийн автомашин, мотоциклын парк шинэчлэлт хийх талаар ЭМЯ болон УИХ-ын гишүүдэд санал хүргүүлж шийдвэрлүүлнэ.

1.2 Боловсролын бодлого

- 1.2.1 Сургуулийн дотуур байрыг шинээр бариулах ажлыг хөөцөлдөнө. \байрын сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх спорт заал, бассейн, урлаг заал, жем, интернет орчин кофе шоп, бага насын сурагчдын гадна доторх тоглоомын талбай, бохир цэвэр ус, дотор оо-той\ улсын хэмжээний жишиг дотуур байрын төсвийг улсын төсөвт суулгах ажлыг хөөцөлдөнө.
- 1.2.2 Байгалийн ухааны хичээлүүдэд онцгой анхаар ч лаборатори анги кабинеттай болгож ирээдүйн инженерүүдийг чанартай бэлтгэн, сурагчид БҮ хичээлүүдээр сонгон суралцах байдлыг нэмэгдүүлнэ.
- 1.2.3 Сургуулийн багш нарын өрөөг багш хөгжлийн төв болгон тохижуулж багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж ажиллана.
- 1.2.4 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжин мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулж, ард иргэдтэй хамтран чадварлаг багш хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.5 Хичээлээс гадуурх сургалт, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг сумын өөрийгөө хөгжүүлсэн чадварлаг хариуцлагатай иргэн, ахмад багш нарт тулгуурлан хөгжүүлнэ.
- 1.2.6 Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж монгол бичгийн олимпиадыг иргэдийн дунд жил бүр уламжлал болгон явуулна.



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 1.2.7 Гэр бүлд зөвөлгөө өгөх танхимыг сумдад байгуулж, бүх нийтийн соён гэгээрэл гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээний орчин нөхцлөл, хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.2.8 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, хохироогчид чиглэсэн үйлчилгээ, орчин нөхцлийг стандартад нийцүүлж, хамтарсан багийн ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.

1.3 Соёл спорт

- 1.3.1 Урлаг спортын үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 1.3.2 Залуучуудын хөгжлийг дэмжин сагс, волейбол, хөл бөмбөгийн стандарт талбайг байгуулахыг дэмжинэ.
- 1.3.3 Соёлын төвийн ажилчид эрхлэгч багш номын санчдыг сургалтанд хамруулж чадвахжуулахад анхаарч хамtran ажиллана.

1.4 Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт .

- 1.4.1 Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг эмэгтэйчүүдэд олгож хамtran ажиллах боломж нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.4.2 Шинэ залуу малчдыг дэмжин малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.3 Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд баялагын сан, нийгмийн даатгалын сангаар болон ипотек, 3%-ийн зээлээр дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдээ орон сууцжуулах төрийн бодлогыг сумандаа хэрэгжүүлэнэ.
- 1.4.4 Хөдөлмөр зуслан болон хүүхдийн зуслантай болгох хувийн хэвшлийн үүсгэл санаачлагыг дэмжинэ.
- 1.4.5 Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллын үйлчилгээг сайжруулж, хүүхдэд ээлтэй сум болгоно.
- 1.4.6 Хүүхэд хамгааллын багийн мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллын ажлыг хэрэгжүүлж иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.4.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт хандлагыг ард иргэдийн дунд төлөвшүүлж ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох, хөгжих боломжийг бий болгоно. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орлогыг нэмэгдүүлэх мэдлэг туршлага сумынхаа залуучуудад зааж өвлүүлж үлдэх нөхцөлийг бүрдүүлнэ

0000000005

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 1.4.8 Сумандаа гал унтраах галын машинтай болж төрийн албан хаагчид болон сайн дурын иргэдийг гал унтраах сургалтад тогтмол хамруулах.
- 1.4.9 Хүүхэд хамгааллын багийн талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нэлөөллын ажлыг хэрэгжүүлж иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.4.10 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаарх зөв ойлголт хандлагыг ард иргэдийн дунд төлөвшүүлж ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох, хөгжих боломжийг бий болгоно.
- 1.4.11 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орлогыг нэмэгдүүлэх мэдлэг туршлага сумынхаа залуучуудад зааж өвлүүлж үлдэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. ХАА-н үйлдвэрлэлийн талаар:

- 2.1.1 Хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийг бэхжүүлж мал амьтны гаралтай өвчний голомтыг устгах ариутгах халдвартгүйжүүлэх ажлын үр дүнг дээшлүүлж, мал эмнэлэг ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.
- 2.1.2 Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриалж төрийн худалдан авалтад орон нутгийн үйлдвэрлэл бизнес эрхлэгчид оролцохыг дэмжинэ.
- 2.1.3 Сумын нэг өдөр үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж сумын брэндийн нэр төрлийг нэмэгдүүлж баялаг бүтээгчдээ дэмжинэ.
- 2.1.4 Мал нядалгааны бойн цэгийг улирлын ажиллагаатай болгож иргэд малаа зориулалтын цэгт муулна. \худаг, тог, халаалт, байрыг шийдвэрлэнэ.
- 2.1.5 Жил бүр Тосонцэнгэл сумыг аварга шалгаруулах адуучин тэмцээнийг зохион байгуулж адуун соёлыг тээсэн залуу малчдыг бий болгоно.
- 2.1.6 Зудын эрсдэлийг даван туулах өвөлжөө төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.7 Өвлийн хүлэмжийг бий болгох айл өрх аж ахуй нэгжүүдийг дэмжиж жилийн 4 улиралд шинэ ногоо хэрэглэх боломжоор хангана.

2.2 Жижиг дунд үйлдвэрлэл

- 2.2.1 Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд мал амьтны гаралтай арьс шир, үс, ноос ноолуурыг боловсруулж жижиг цех үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 2.2.2 Тосонцэнгэл суманд 4 улиралын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуй болон гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.
- 2.2.3 ажлын байр бий болгох тогтвортой үйл ажиллагаа явуулах дараах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.

Үүнд:

- Тоосго блокны үйлдвэр
- Ахуй үйлчилгээ
- Талх гурилан бүтээгдэхүүний цех
- Бордоо боловсруулах цех

2.3 ТӨСӨВ САНХҮҮ- СТАТИСТИК

- 2.3.1 Орон нутгийн татварын бааз суурийг өргөтгөн, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2 Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудыг чадавхижуулана.
- 2.3.3 Төр хувийн хэвшлийн статистик, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт тооцооллыг сайжруулж, цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэнз.
- 2.3.4 Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимыг баримталж, төсвийг үр дүнтэй зарцуулана.
- 2.3.5 Орон нутагт хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, Хоршоо хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан бусад сангидын үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулана.

3. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1 Тэр-бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд

- 3.1.1 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлгийн газруудыг дэмжиж, байгууллага, ААН, иргэнд хөнгөлттэй үнээр үрсэлгээ авах боломжийг бүрдүүлнэ.
- 3.1.2 Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн менежментийг хэрэгжүүлэнз.



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 3.1.3 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлж, айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аяныг өрнүүлж, бодлогоор дэмжинэ.

3.2 *Ногоон сум хөтөлбөр*

- 3.2.1 Ойн хөнөөлт шавжийн тархалт өсөлт бууралтыг хяналтад авч мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
- 3.2.2 Сумын газар зохион байгуулалттай холбоотой үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлж газрын харилцаа холбоотой орон зайн өгөгдөл мэдээллийн хүртээмжийг нээлттэй ил тод болгоно.
- 3.2.3 Гадаргын усны урсгалыг сайжруулж үерийн ус хуримтлуулж хиймэл цөөрөм үүсгэнэ.

4. ДЭД БҮТЭЦ СУМЫН ТОХЬЖИЛТЫН БОДЛОГО

4.1 *Дэд бүтэц*

- 4.1.1 Тосонцэнгэл сумын хөгжлийн өрөнхий бодлого төлөвлөгөөг боловсруулж баталуулна.
- 4.1.2 Сумын төвийн халуун ус, соёл, спортын цогцолбор төв барих ажлуудыг улсын болон аймаг орон нутгийн төсөвт суулган хэрэгжүүлнэ.
- 4.1.3 Сумын төвдөө 32 айлын орон сууцыг барьж залуу гэр бүлд таатай нөхцөлөөр амьдрах боломжийг бий болгоно.
- 4.1.4 Айл өрх ААН-ийн гадна талбайн 30%-ийг ногоон байгууламж болгоно.
- 4.1.5 Сүүл-Улаан багийг үүрэн холбооны 4G сүлжээнд холбоно.

4.2 *Сумын төвийн тохьжилт*

- 4.2.1 Хог ангилах аргыг айл өрх бүрд сурталчлан таниулж хогоо ангилдаг өрх гудамж байгууллагыг дэмжин ажиллана.
- 4.2.2 Золбин нохой муур устгалт, хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажлыг тогтмолжуулж, хууль журмуудын хэрэгжилтийг ханганд ажиллана.

6. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 6.1 Төрийн албан хаагч сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд хурдан шуурхай, ил тод, ялгамжгүй, шударга хүртээмж үзүүлнэ.
- 6.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод болгон 7 хоногт нэг өдөр ард иргэдэд цахимаар мэдээлэл өгнө.




ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 6.3 Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулж төрийн байгууллагуудын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж хүнд суртал үүсгэж буй үйлчилгээнүүдийг цахимжуулна.
- 6.4 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.
- 6.5 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх явцуу сонирхол намын харьяалалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 6.6 Төр иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж авлига албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулж эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болгоно.
- 6.7 Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвортой суурьшилтай ажиллуулна.
- 6.8 Төрийн байгууллагын менежеметийг сайжруулж зохион байгуулалт хийж ажилчдын ажиллах ээлтэй орчинг бүрдүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн:

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын

Монгол Ардын Намын Хороо



0000000009